



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-21

1.“Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	4-21
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 43 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Хосбаяр;

Чөлөөтэй: Н.Батсүмбэрэл, Б.Дэлгэрсайхан, Н.Номтойбаяр, Ө.Шижир, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Э.Болормаа.

Нэг. “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга Б.Лхагвадэмбэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ч.Батбямба, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Х.Жангабыл, Л.Энхнасан, С.Эрдэнэболд, Д.Ганбат нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга Б.Лхагвадэмбэрэл нар хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 57 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их засаг” танхим 10 цаг 02 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Сүхбаатар Эрдэнэболд гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хорооны ирц бүрдсэн байна аа. Та бүхэнд хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хоёр асуудал байгаа.

Нэгдүгээр асуудал эрчим хүч 3 төслийг хэрэгжүүлэх Монгол Улс Европын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай төсөл байгаа Засгийн газар. 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн соёрхон батлах асуудал байна.

Хоёр дахь асуудал нь Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Цахим аюулгүй байдалтай холбоотойгоор ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг Байнгын хорооны гишүүдээс санал гаргасан. Ийм 2 асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Анар гишүүн. Анар гишүүнийг микрофон өгье.

Ч.Анар: Өдрийн мэнд.

Кибер аюулгүй байдалтай холбогдолтой ажлын хэсгийн тогтоолын төсөл дээр Инновац цахим бодлогын байнгын хорооноос хамтарсан тогтоол гаргах санал гаргасан. Тэгээд үндсэндээ зарчмын хувьд зөв зүйтэй гэж үзэж байгаа учраас хэлэлцэх асуудлыг дарааллын солиод энэ удаагийн хурлаас дараагийн хэлэлцэх асуудал руу оруулж өгөөд татахыг хүсэж байна аа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо энэ асуудлыг Анар гишүүний саналаар горимын санал хураалгах юм байна. Горимын санал гаргаж байна.

Байнгын хорооны тогтоолын төслийг 2 байнгын хороодын хамтарсан тогтоолын төсөл байх ёстой гэсэн цахим бодлогын байнгын хороо болоод Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан тогтоолын төсөл гаргая гэсэн горимын саналыг гаргаж байгаа юм байна. Санал хураалтыг явуулна гишүүдийг гишүүдийг дуудаж оруулж ирье тэгээд санал хураалт горимын саналаар явуулна аа.

Горимын саналтай холбогдуулаад санал хураалтыг явуулна. Шинэ юугаар явах ёстой байгаа. Санал хураалтын бэлэн байдалд шилжье. Бүгд санал хураалтын бэлэн байдалд шилжье. Бүгд төхөөрөмжөөс гарчихсан байгаа байх. Буцаагаад

хуруугаа хийцгээнэ. Төхөөрөмжүүд холбогдсон байна. Бүх гишүүд орчихсон байна уу? Хуруугаа уншуулаарай Эрдэнэболд гишүүн. Санал хураалт горимын санал авах гээд байгаа юм. Шинэ горимоороо.

Ингээд Анар гишүүнийхээр Байнгын хорооны тогтоолын төслийг хойшлуулах асуудал байгаад байгаа. Тэгээд энэ дээр санал хураалт явуулъя.

Гишүүд анхааралтай санал хураалт.

2 дугаар асуудлыг хойшлуулах горимын саналыг гаргаж байна.

Горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт.

Санал хураалт 69.2 хувиар дэмжигдлээ.

Ингээд 2 дахь асуудлыг хойшлууллаа.

Асуудалдаа орьё. “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс Олон Улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлтсийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгээс хийнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг бүхэнд танилцуулъя. Эрчим хүчний сайд Чойжилсүрэн. Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт дарга байна. ЭХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Энхтүвшин, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг.

Баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцууллаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн эрчим хүчний сайд Чойжилсүрэн сайд танилцуулна аа. 4 номер таныг микрофонд урьж байна.

Б.Чойжилсүрэн: Эрхэм байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улс олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын Эрчим хүч 3 төслийн зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороодоор 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хэлэлцэн эмж дэмжсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 7 дугаар захирамжийг үндэслэн зээлийн хэлэлцээрт 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдөр гарын үсэг зураад байна аа. Тус төсөл нь шинэ сэргэлтийн бодлогын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн жагсаалтад туссан бөгөөд Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцэж байгаа болно.

Төслийн хүрээнд одоогийн Багануур Чойр чиглэлийн 110 киловольтын ЦДАШ-ыг 220 киловольтын 2 киловольт болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, Багануур, Чойр дэд станцуудыг өргөтгөснөөр бүс нутгийн өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрчим хүчний найдвартай ажиллагаа тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой юм аа. Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкнаас олгох 47 сая ам долларын зээлийн хугацаа 30 жил, үүнээс үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 5 жил бөгөөд баталгаат овернац санхүүжилтийн хүүн дээр софр дээр нэмэх нь 1.44 хувийн нэмэгдэлтэй хувьсах хүүтэй болно. Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу Эрчим хүч-3 төслийн зээлийн хэлэлцээр нь Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах олон улсын гэрээ тул зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Энхнасан гишүүнээр тасалъя. Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье ээ.

Энэ 44 сая долларын зээлийн асуудал яригдаж байгаа юм байна аа. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээ бол жилээс жилд нэмэгдэж байгаа. Тэгэхээр та бүхэн судалж үзсэн үү? Заавал одоо зээл авч хийхгүйгээр ямар нэгэн байдлаар, дотоодын одоо үндэсний ААН-үүд хамтраад ч юм уу төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ч юм уу энэ ажлыг одоо хийх боломж байсан уу үгүй юу гэдэг дээр та бүхэн ямар судалгаа хийсэн юм болоо гэсэн нэг ийм асуулт байна аа.

Дараа нь энэ говийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ бол мэдээж одоо томоохон төслүүд хэрэгжихтэй холбогдуулаад нэмэгдэж байгаа. Өнөөдөр гэхэд зарим одоо говийн бүсийн сумдууд Хятадаас цахилгаанаа авч байгаа. Тухайлбал Өмнөговийн баруун талын 3 сум Хятадаас цахилгаанаа авч байгаа. Байнгын тасалдана, үнэ нь өндөр. Тэгээд дураараа одоо тасалж яадаг. Хэрэглэгчдийг бас төвөгтэй нөхцөл байдал үүсгэдэг. Тэгээд олон удаа санал өгч байсан. Аймгийн төвөөс нь холбож өгөөч ээ. 220 км эхний сум нь байгаа юм. Холбоод өгчих юм бол цаашаа нөгөө 2 сумтай гурвуулаа холбогдох юм байгаа юм.

Тэгээд ер нь энийг одоо ирэх жилийн төсөвт байдаг юм уу, ямар нэгэн зээлийн хөрөнгө байдаг юм уу одоо шийдэх бололцоо байна уу үгүй юу гэдэг дээр нэг хариулт өгөөч.

Тэгээд 3-д нь Өмнөговийн 50 мвт-ын станцыг ер нь яаж цааш нь явуулахаар бодож байгаа вэ гэсэн нэг ийм 3 асуулт байна аа тэгээд тодруулъя аа.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд 4 номер.

Б.Чойжилсүрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Яг энэ төслийн тухайд бол Багануур Чойрын цахилгаан дамжуулах агаарын хос шугам байгаа. 220 киловольтын шугамаар явж байгаа. Энэ төсөл хэрэгжих юм бол дараагийн удаад бол Шандаас Цагаан суварга руу бас нэг 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ийм төлөвлөгөөг хийгээд ерөнхийдөө эх үүсвэр нь тодорхой болж явна. Энэ 2 шугам одоо өнөөдөр Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас Чойр Сайншанд энэ 220 киловольтыг нь цахилгаан дамжуулах агаарын шугамын холбогдох дэд станцуудын өргөтгөлүүдтэй тендер нь зарлагдаад явж байгаа юм.

Энэ шугам ашиглалтад орчих юм бол бид нар Монгол Улсын Засгийн газар төвийн эрчим хүчний системээсээ Оюу Толгой төсөлд 1.3 квт цаг эрчим хүч жил болгон нийлүүлнэ ээ гэдэг ийм гэрээг хийчихсэн байгаа юм. Тэгэхээр одоо нэг талынх нь найдвартай хангамжийг бүртгэх ийм төсөл. Түүнээс гадна говийн бүсэд сэргээгдэх эрчим хүчний төслүүд олноор бий болж байгаа. Энийг бол төвийн бүс рүү дамжуулах ийм бололцоотой байгаа. Хувийн компани яг энэ төсөл рүү хөрөнгө оруулаад өөрийнхөө оруулсан хөрөнгөө ашигтай буцааж авах ийм ямар ч нөхцөл тооцоолол гарахгүй байгаа учраас засаг энэ цахилгаан дамжуулах агаарын шугам хуваарилах байгууламжуудыг засаг өөрийн одоо зээл аваад хийхээс өөр бололцоо байхгүй гэсэн ийм шийдэлд хүрсэн учраас түрүүчийн удаа танай Байнгын хороогоор ч бид нар танилцуулсан бөгөөд зөвшилцсөн.

Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороон дээр ч энэ асуудлуудаа танилцуулсан. Ийм байдалтай байгаа.

Манай улсын тухайд бол нөгөө өргөн уудам нутагтай 1.5 сая квадрат нутаг 3.5 сая хүнтэй. Яг цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн хувьд бол олон улсын стандартаар хэт сийрэг ийм байгаа юм. Танай аймгийн 3 сум сумууд би Гурван Тэс, Ноён, Сэврэй энэ сумдад Хятадаас цахилгаан эрчим хүч авч байгаа, импортолж байгаа. Харамсалтай нь өндөр байна. Төвийн бүсээс энэ у гурван тэс рүү хүргэхэд бараг мянга шахуу километр очно. Шугамын алдагдал өндөр учраас энэ өнгөрсөн үед бол манай эрчим хүчний салбарынхан төвийн бүсээс хангах дээр бол шугамын алдагдал хэт өндөр байгаа учраас үр ашиггүй тооцоо гараад байсан юм байна лээ. Одоо танай аймгийн тухайд бол Даланзадгад дээр 1 50 мвт-ын хүчин чадалтай цахилгааны эрчим хүчний тухайд. Дулааных нь эрчим хүч нь бол жоохон эцэслээгүй байна. Одоо удахгүй нэг талд нь гаргана. ТЭЗҮ нь дуусаж байгаа. Энэ Даланзадгад энэ 50 мвт-ын хүчин чадалтай цахилгаан станц ашиглалтад орчих юм бол Даланзадгад, Ноён, Сэврэй, Гурван тэс гэдэг энэ чиглэл рүү цахилгаан дамжуулах агаарын шугам холбогдох хуваарилах байгууламжуудыг барих бололцоотой. Бид нар ирэх жилүүдэд бол ийм тооцоо судалгааг хийгээд явж байгаа ийм л байдалтай байгаа.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Баярлалаа. Дэлгэрэнгүй танилцуулга дээр Ханбогд сумын 250 мвт-ын салхин цахилгаан станцаас буцаагаад энэ шугамаараа татаад төв рүүгээ нийлүүлнэ гээд тавьсан байх юм. Тэгээд би л сонсоогүй байх юм. Тийм юм барьчихсан юм уу?

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд хариулъя. 4 номер.

Б.Чойжилсүрэн: Ханбогд дээр бол нөгөө сэргээгдэх эрчим хүчний өндөр өртөгтэй ийм төсөл, тусгай зөвшөөрөл авчхаад олон жил болж байгаа бид бол үнийг нь буулга гэдэг ийм зориулалт шаардлага тавьчихаад тухайлбал 15 центээр 1квт цаг эрчим хүчийг нийлүүлнэ гэдгийг. Бид нар бол 10 центээс өндөр үнээр авч чадашгүй нь ээ, нэг.

Хоёрдугаарт салхины чинь хувьсах чадвар өндөр байгаа учраас одоо нийлүүлж байгаа хүчин чадлынхаа 40 хувьтай тэнцэх хэмжээний 4 цэгийн гаргалгаатай батарей станц барих юм бол бид нар нийлүүлье ээ. Төвийн эрчим хүчний системд холбоё гэдэг ийм буулт хийгээд 2 талаасаа энэ ажил явж байгаа юм.

Тэгэхээр одоо энэ бидний тавьсан Эрчим хүчний сайдын дэргэдэх зөвлөлийн энэ шийдвэрийг нөгөө хөрөнгө оруулагч тал хүлээж аваад явах юм бол сүлжээнд холбогдож таарна. Тэгэхээр энэ шугамаар цахилгаан эрчим хүч төвийн бүс рүү нийлүүлэгдэж таарна. Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе ээ. Эрчим хүч нэг эрчим хүч 2 төслүүд урьд өмнө нь Монгол Улсад амжилттай хэрэгжсэн. Одоо эрчим хүч 3 төслийг одоо ингээд оруулаад ирсэн байна. Эрчим хүчний инженер хүний хувьд энэ төслийг дэмжиж байна аа. Энэ төсөл хэрэгжсэнээр Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий гээд аймгууд, 6 аймаг. Дээр нь ер нь одоо сумын цахилгаан хангамж 100 гаруй уул уурхай, ашигт малтмалын газруудын одоо хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчний найдвартай чанартай хангамжтай болох байна гэж ойлгоод байгаа.

Тэгэхээр энэ төсөлтэй холбоотой хэд хэдэн асуулт байна аа. Одоо энэ танилцуулга дээр Багануур, Чойр чиглэлийн өндөр хүчдэлийн шугамыг одоо 220 байгаа л даа. Нэг хэлхээтэй. Энэ танилцуулга дээр 110 гээд биччихэж. Энийг засах хэрэгтэй байх аа.

Хоёрдугаарт Чойроос Сайншандын өндөр хүчдэлийн шугам одоо баригдаж байгаа. Сайншандаас Замын-Үүдийн одоо шугам хэзээ баригдах юм бэ? Аливаа төслийг цогцоор нь хийвэл зүгээр юм л даа. Тэгэхээр одоо бол Чойроос Сайншанд хооронд баригдаж байгаа цаашаагаа Замын-Үүд хүртэл шугам баригдах хугацаа хэзээ баригдахыг хэлж өгөх шаардлагатай байна аа. Тэгээд одоо байгаа Багануур, Чойрын шугамын алдагдал яг одоо хэд байгаа юм бэ? Энэ төсөл хэрэгжсэнээр алдагдал нь хэдэн хувьтай одоо болох юм бэ? Техникийн болон техникийн бус алдагдлууд байдаг л даа. Техникийн бус гэдэг нь одоо хулгайч юм уу? Техникийн алдагдлын хувьд шинэ шугам одоо ямар утсаар баригдах юм. Трансформатор тоноглолууд нь ямар шаардлага хангасан юм бэ? Энэ дээр Детальный нарийн одоо мэдээлэл авмаар байна.

Дараачийн асуулт Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц их эрчимтэй баригдаж байна. Дээрээс нь нарны цахилгаан станцуудыг барихаар бас төслүүд хэрэгжээд ЭХЯ-ны одоо төлөвлөлтөд орсон бэлтгэл ажлаа хийгээд байна.

Сэргээгдэх эрчим хүчийг бас давхар хөгжүүлж энэ УЦС-даа уялдуулах нь зөв л дөө. Тэгэхээр энд нэг асуулт байна аа. Энэ Эрдэнэбүрэнгээс Мянгад сум хүртэл өндөр хүчдэлийн шугамыг татчих байх аа барьчих байх. Мянгадаас энэ Улиастайг

хүртэлх шугамыг хэзээ барихаар байна аа? Энэ баруун бүсийн эрчим хүчийг төвийн бүсийн эрчим хүчинд холбочихвол их ашигтай л даа.

Дээрээс нь эрчим хүч баруун бүсэд бол.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд хариулъя. 4 номер.

Б.Чойжилсүрэн: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Манайхан бэлтгэж байгаарай. Яг шугамын алдагдлын тухайд бол Багануур, Чойр төслийг одоо ингээд бүхэн хэлэлцээд сууж байна. Чойроос Сайншанд нь баригдаад явж байгаа. Шандаас Замын-Үүд рүү бол бид нар Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл хийх хэрэглээ ямар хэмжээнд өсөх вэ гэдэг энэ судалгааг хийгээд явж байгаа. Мэдээж бид нар нөгөө эх үүсвэрийн дутагдалтай байдаг учраас тэргүүн ээлжийн эгнээнд эрэмбэд орж ирээгүй байгаа. Бид нар энэ цахилгаан дамжуулах агаарын шугам хуваарилах байгууламжуудыг Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Европын сэргээн босголтын банк тэргүүтэй энэ олон улсын байгууллагууд энэ хямд эх үүсвэртэй зээлд хамруулахаар ярьдаг. Одоохондоо бол танд яг энийг бол яг шийдчихсэн ийм төсөл байхгүй байгаа.

Бид нар бол зүгээр манай ЭХЯ-аас Сангийн яаманд саналаа хүргүүлдэг. Энэ эдгээр байгууллагууд дээр бол дараагийн ээлжид бол энэ төслийг одоо хөгжүүлэх талаар анхааралдаа аваач ээ гэдэг ийм л хэмжээндээ яваа учраас яг өнөөдөр бид танд тэдийд өдийд гэдэг ийм одоо амлалт өгч чадашгүй нь ээ.

Багануур, Чойрын асуудлыг одоо бид нар. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын ажил одоо ямар ч байсан нэг ийм гацаанаас явж байгаа. Гэхдээ л ер нь нэг улс төржүүлчих гээд л Хятадын тал ямар нэг байдлаар нэг улс төрийн шалтгаан гарахаараа энэ чинь зогсож магадгүй шүү гэж айлгаад л ийм байдалтай явж байгаа. Одоохондоо бол маш сайн ажил нь явж байгаа. 2029 онд ашиглалтад оруулах байдалтай байна. Та бас цахилгааны инженерийн хувьд бол УЦС-ын хажууд бид нар нарны цахилгаан станц болон холбогдох тодорхой хэмжээний горим тохируулга дээр тооцоо бодоод тодорхой хэмжээний батарей эх үүсвэртэйгээр ийм тендер зарлахаар манай ЭХЯ-ан дээр ажлын хэсэг үнэлгээний хороо байгуулагдаад явж байна. Диспетчерийн үндэсний төв болон эрчим хүчний зохицуулах хороотой ойрын хугацаанд энэ сардаа магадгүй энэ ирэх 6 дугаар сардаа багтаагаад тендерийн бүх тооцооллуудыг бэлэн болгоод надад танилцуулна гэсэн. Ийм байдалтай байгаа. Эрдэнэбүрэн Мянгад станцын тухайд нэг асуудал үүссэн.

Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг бид нар Хятад улсын Эксим банкны санхүүжилтээр явж байгаа. Азийн хөгжлийн банк энэ төслийг санхүүжүүлэх ёстой байсан чинь нэмэлт шаардлагууд тавиад болдоггүй ээ. Тэгээд одоохондоо бол ажил нэг их урагшаа явахгүй байна. Ямар ч байсан Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын ажил нь эхэлсэн учраас бид нар эхний эхний ээлжид Эрдэнэбүрэн Мянгадын 220 киловольтын хос дамжуулах агаарын шугамыг ойрын жилүүдэд маш яаралтай бүр шаардлагатай бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих шаардлага үүссэн. Мянгад, Улиастай чиглэлийн тухайд бол бараг 400 гаруй километр урт болон 100 гаруй сая долларын өртөгтэй болно. Жилд дамжуулах цахилгаан эрчим хүчний хэрэглээг өнөөдрийн байдлаар 5 сая доллароос илүү дээшээ гарч өгөхгүй байгаа учраас Мянгад Улиастай чиглэлийн цахилгаан дамжуулах 220 киловольтын агааран дамжуулах шугамыг АХБ-тай хэлэлцээрт явуулж байгаад төр одоо жоохон тийм саатчихсан байгаа байдалтай байна.

Энэ Мянгад Улиастайн хооронд ч гэсэн энэ УЦС дээр тавигдах шаардлагуудаа АХБ нэмэгдүүлээд байгаа учраас бидний хувьд төвөгтэй байна. Эхний ээлжид ямар ч байсан гарцаагүй ойрын жилүүдэд одоо ирэх 2026 оны төсөв байна уу, ондоо санхүүжүүлэгч болох юм уу? Бид нар Эрдэнэбүрэн Мянгадын 220 киловольтын цахилгаан тоногжуулах агаарын шугамыг бол гарцаагүй Монголын талд хийхээс таарахгүй. Хятадын Эксим банктэй хийсэн гэрээн дээр ч гэсэн энийг бол Монголын тал хариуцна гэдгээ бид нар амлалт өгөөд энэ төсөл хэрэгжээд эхэлчихсэн ийм байдалтай байгаа. Манай залуучууд хэн хариулах юм? Тэр шугамын алдагдлын тухай.

Г.Тэмүүлэн: Багануур, Чойрын алдагдалтай холбоотой асуудлыг хэдэн номер хариулах вэ? 2 номер Эрчим хүчний яам.

Б.Лхагвадэмбэрэл: Гишүүний асуултад хариулъя аа Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга Лхагвадэмбэрэл байна аа. Уг төслийн хүрээнд бол Багануур Чойрын 220 киловольтын шугам 188км-ийн 2 хэлхээ агаарын шугам байж байгаа. Шугамын тоноглолын хувьд бол Багануур дэд станцын 220 киловольтын өргөтгөл шугамтайгаа Чойр дэд станцын 220 киловольтын өргөтгөлтэйгөө орж ирж байгаа. Энийг дагаад трансформатор хүчний тоноглолууд бол байхгүй. Шугам өргөтгөлийн тоноглолууд энэ төсөлд тусгагдсан байж байгаа. Одоогийн байдлаар болохоор энэ Замын-Үүд хүртэл 110 киловольтын нэг хэлхээ шугам Чойр дэд станцаас одоо хүртэл холбогдож ажиллаж байгаа. Энэ хооронд бол одоо суурилагдсан хүчин чадлаараа 125 мвт-ын сэргээгдэх болон нарны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадал бүхий сэргээгдэх эрчим хүчний системүүд үүсгүүрүүд холбогдож ажилладаг. Нийтдээ 38 мянган хэрэглэгчдийг хангаж ажиллаж байгаа ийм шугам байгаа юм аа.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн нэмж тодруулъя.

Х.Жангабыл: Багануур Чойрын одоо байгаа нь 220 нэг хэлхээтэй. Энийг одоо 2 хэлхээтэй болгох гэж байгаа.

Тэгэхээр өмнө байсан тулгуурыг ашиглах юм уу зэрэгцээ барих юм уу нэмж. Тэгээд Чойжоо сайдад захиж хэлэх юм байна аа. Мянгадаас энэ Улиастайн чиглэлийн 420 км-ийн өндөр хүчдэлийн шугамыг одоогоос бодож ирээдүйгээ ч бодож одоо холбох ажлыг хариуцаж энийг хийлгэхгүй бод Баруун бүсийн эрчим хүчийг Төвийн эрчим хүчний системд холбох нь асар их ач холбогдолтой гэдгийг өөрөө мэдэж байгаа. Энэ одоо төслийг та бас хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна аа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: 4 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Жангабыл гишүүн санал хэлчихлээ. Ер нь энэ Мянгад Улиастай хэт хол. Баруун бүсийн хэрэглээ Алтай Улиастайн эрчим хүчний системийн хооронд явна. Одоогийн яг өнөөдрийн байдлаар ойрын жилүүдэд ашиглалтад орууллаа гэж бодоход жилдээ нэг магадгүй тавхан сая долларын үнийн дүнтэй цахилгаан эрчим хүч нааш цааш дамжуулах юм байна лээ. Авах зээл нь. 100 гаруй сая доллар байгаа учраас банк элс нот болчхоод болдоггүй. Манай эрчим хүчний салбар чинь өөрөө өндөр алдагдалтай байгаа учраас одоохондоо жоохон

баруун бүсийн эрчим хүчний хэрэглээ нэмэгдтэл жоохон хүлээх вий дээ гэсэн ийм байр суурь дээр л байгаад байгаа юм. Сангийн яам ч ийм байр суурьтай байгаа.

Тэгэхгүй бол байгаа хэмжээндээ хөнжлийнхөө хэрээр хөлөө жий гэдэг шиг ингэхгүйгээр хэт өөдрөг харах юм бол наана нь тэр ирээдүйдээ хүрэхгүйгээр системийн алдагдал өндөр болчих гээд эргэн төлөх өрийн хэмжээ, зээлийн хэмжээ манай эрчим хүчний систем дээр өндөр болчихоод төлж чадахгүй байдал найдваргүй зээлдэгчийн ангилалд орчих учраас бид нар жоохон болгоомжтой байгаа юм. Гэхдээ таны саналыг сонслоо.

Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай, Улиастайн эрчим хүчний системийн хооронд хэрэглээ огцом нэмэгдэх ийм одоо хэрэглэгч нар гарч ирэх юм бол одоо энийг явуулна. АХБ-тай сая тодорхой шалтгаанаар бид нар энэ тодорхой хэмжээнд ингээд түдгэлзчихсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүн асуулт асууя.

Л.Энхнасан: Сайн байна уу? Та бүхний өдрийн мэндийг хүргэе.

Энэ эрчим хүч-3 төслийг банкнаас санал болгож байгаа буй зээлийн хөрөнгө нь энэ баталгаат овер найт санхүүжилтийн хувьсах хүү гэж байгаа юм. Дээр нь 1.4 хувийн нэмэлттэй гэсэн байна. Тэгэхээр ер нь энэ соф нь ер нь хэд байдаг юм? Ер нь энэ манай улсад өмнө авсан энэ зээлүүдтэй харьцуулахад хэр энэ таатай нөхцөлтэй гэж тооцогдож байгаа вэ? Зээл нь ер нь улсын өрийн хэмжээнд хэрхэн нөлөөлөх вэ? Нөлөөлөх үү? Засгийн газрын өрийн тогтвортой байдал хангагдах уу? Сангийн яамнаас л илүү асуумаар байна.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүний асуултад хариулъя. 7 номер.

Л.Гантогтох: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Баталгаат овер найт санхүүжилтийн хүү буюу софр хүү маань яг өнөөдрийн байдлаар 4.3 хувьтай байна. Зээлийн хүү маань үүн дээр 1.44 хувийн нэмэгдэлтэй буюу одоогийн байдлаар 5.7 хувь хүү орчим ийм нөхцөлтэй байгаа. Тэгэхдээ энэ бол хувьсах хүүтэй зээл. Хэрвээ цаашдаа зээлийн софр хүү цаашдаа буурах тохиолдолд энэ зээлийн хүү ингээд дагаад буураад буурсан дүнгээрээ төлөгдөөд өсөх тохиолдолд бол өсөх ийм хувьсах хүүтэй байгаа.

Ерөнхийдөө софр хүү бол 0.5-аас 2 орчим хувийн хүүтэй байж байгаад одоо сүүлийн жилүүдэд 2023 оноос эхлээд өсөөд одоогийн түвшинд ингээд хүрчихсэн ийм байдалтай байгаа.

Засгийн газрын өрийн хэмжээнд бол одоо энэ зээл маань 47 сая ам долларын зээл. Тэгэхдээ яг нөгөө гэрээ байгуулагдсан дүнгээр бол шууд Засгийн газрын өр дээр нэмэгдэхгүй. Төсөөлөл маань ингээд 5 жилийн хугацаанд хэрэгжинэ. Хэрэгжсэн жил дээр одоо зээлээс ямар хэмжээгээр авч ашиглаж байна тэр дүнгээрээ ингээд нэмэгдээд явахаар байгаа.

Одоогийн байдлаар нэг жилд нэг 7-оос 10 сая орчим долларын ашиглалт гарна гэж үзвэл 30-аас 40 тэрбум төгрөгөөр Засгийн газрын өр дээр нэмэгдэхээр байгаа. Дунд хугацааны өрийн төсөөлөлд бол энэ зээлийн хэлэлцээр бол орсон. Тэгээд дунд хугацааны Засгийн газрын өрийн төсөөллөөр бол 2026-2028 онд

Засгийн газрын өр ДНБ-ий 40 орчим хувьд ингээд тогтворжихоор ийм төсөөлөлтэй байгаа.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүн нэмж тодруулъя.

Л.Энхнасан: Тэгэхлээр нөгөө зээлийн эргэн төлөх хугацаанд 25 жилийн хугацаанд нөгөө хүү бол өөрчлөгдөх эрсдэл байгаа шүү дээ тиймээ? Энэ дээр эрсдэлийн шинжилгээгээ хийсэн үү? Хийсэн бол ямар нэгэн дүгнэлт гарсан уу?

Г.Тэмүүлэн: 7 номер.

Л.Гантогтох: Авах зээл хувьсах хүүтэй байгаа. Тэгээд хувьсах хүүтэй зээлийг бол авахдаа бид нарт хүүн дээр ямар хэмжээгээр төлөгдөх вэ гэдэг ийм шинжилгээ хийгдэж байгаа. Яг одоогийн байдлаар хувьсах буюу софр хүү маань ерөнхийдөө зах зээлийнхээ зарчмаар нэлээн өндөр түвшинд оччихоод байгаа. Цаашдаа бол энэ 4.3 гэдэг софрын одоогийн түвшин цаашдаа ийм буурах төсөөлөлтэй байгаа. Тэгэхээр 1 жилд төлөгдөж байгаа хүүгийн хэмжээ бол цаашдаа буурна гэсэн ийм төсөөлөл байна.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд нэмж хариулъя. 5 номер.

Б.Жавхлан: Энхнасан гишүүний асуултад зүгээр нэмж мэдээлэл өгөхөд манай улс нөгөө буурай орныхоо ангиллаасаа гарсан. Тийм учраас манай хүү нэмэгдэж байгаа. Нөгөө нэн хөнгөлөлттэй зээл авах бидэнд олдохоо больж байгаа гэсэн үг. Цаашдаа манай зээлжих зэрэглэл сайжрах тусам бид улам л өндөр босготой зээл маань, хүү нь нэмэгдээд явна. Цаашдаа авах зээлүүд маань. Тийм учраас зөрөөд бид нар зээлийн ашиглалт, үр өгөөж дээр маш одоо онцгой анхаарах хэрэгтэй юм байгаа юм. Гол эрсдэл ерөөсөө л энэ. Аль болох төслүүдийг бид яг өөрөө өөрсдөө санхүүждэг. Төсөл нь өөрөө одоо ямар нэгэн төсөв дээр эрсдэл авчрахгүйгээр цаашид орлогоороо бүрэн аваад явчих тийм төслүүдийг л цаашдаа улам санхүүжүүлэх хэрэгтэй.

Одоо бидний яг яригдаж байгаа дараагийн 3 жилийн гадаад өрийн стратеги дээр бид нар яг энэ зарчмаа хадгалж байгаа гэсэн үг. Ийм дэд бүтцүүд дээр одоо яах аргагүй бид нар энэ зээл авахаас өөр арга байхгүй. Харин энэ дэд бүтцүүдийн үзвэрүүд дээр нь хувийн хэвшлийнхэн, хөрөнгө оруулагч.

Г.Тэмүүлэн: 5 номер нэмээд хариулъя.

Б.Жавхлан: Илүү их өндөр үр өгөөжтэй ийм төслүүд цаашаа одоо залгагдаад явах ёстой ийм юм байгаа юм.

Дээрээс нь өрийн хэмжээ асууж байна. Тэгэхээр ингэх юм байгаа юм. Энэ одоо ингээд хэдүүлээ зээл авах эрхийг нь нээхэж байгаа гэсэн үг. Одоо Их Хурал дээр соёрхон батлаад. Ашиглаж байгаа хэмжээгээрээ өрөн дээр нэмэгдэнэ. Ашиглалтын хязгаарыг бид нар энэ жилийнхээ төсөв дээр Их Хурлаараа батлуулаад авчихсан байгаа. 1.5 их наяд төгрөг дотор багтаагаад энэ олон зээлүүдийнхээ батлуулсан зээлүүдийнхээ ашиглана шүү гээд. Тэгээд энэ хэмжээн дотроо энэ ашиглалт маань ашигласан хэмжээгээрээ бүртгэгдээд явна зээл дээр. Тэрнээс биш энэ жилийн батлагдсан өрийн хязгаар энэ юмнууд дээр өөрчлөлт орохгүй ээ гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: Би Сангийн сайд болон Эрчим хүчний сайдаас тус тусад нь асуулт асууя аа. Тэгэхээр яах вэ сая ерөнхий хариулчихлаа. Тэгэхдээ 47 сая доллар 30 жилийн хугацаа 2055 он хүртэл гэж гарч байна. 5 жилийг нь чөлөөлнө. 1.44-ийн хувьсах хүүтэй гээд. Тэгэхээр яг Сангийн сайдын хувьд энэ бол яг одоо ингээд гарцаагүй шийдэл үү? Түрүүн одоо эндээс асуугаад байсан шиг магадгүй үндэсний консорциум ч гэдэг юм уу, дотоодоосоо хувийн хэвшилтэй төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар энэ боломжтой байсан уу үгүй юу?

Тэгэхээр яах вэ? Би протоколд үлдээх гэж байгаа нь Сангийн сайдын хувьд энэ бол яг ингээд гарцаагүй шийдвэр үү? Нэг.

Хоёрдугаарт 30 жилийн хугацаанд яг одоо ингээд мөнгөн дүнгээрээ яах вэ тэр танилцуулга дээр болохлоороо нийгэм эдийн засгийн сөрөг үр дагаваргүй гэж байгаа. Тэгэхээр нийгэм эдийн засгийн эерэг үр дагавар нь ер нь мөнгөн дүнгээр болон одоо энэ ач холбогдол талаасаа ингээд симуляц хийж үзсэн үү. Энэ дээр ер нь ямар боломжууд харагдаж байгаа вэ гэсэн нэг асуулт байна. Эрчим хүчний сайдаас болохоор бид нар 2010 онд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг Улсын Их Хурал батлаад тэнд 2 том зорилт дэвшүүлсэн. Нэг нь болохоор нөгөө дотоодоосоо одоо шатахууныг ингэж бүр бие даасан байдалтай хангадаг болно гэсэн зорилго тавьсан.

Нөгөөдөх нь болохоор эрчим хүчний тусгаар тогтнолтой болно гээд 2020 он гэхэд бүр хугацаа заагаад. Тэгэнгүүт өнөөдөр 2025 он эрчим хүчний тусгаар тогтнол бие даасан байдлын асуудал мөн шийдэгдээгүй байна. Тэгэхээр одоо сураг сонсох нь ээ ер нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дараагийн бичиг баримтын төсөл яваад байгаа юм байна гэж ойлгосон. Энэ дээр жишээлбэл энэ бие даасан энэ чинь тусгаар тогтнолтой холбоотой, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал учраас ер нь тусаж орж ирж байгаа юу? Ер нь Монгол улсын хэмжээнд том зургаараа энэ эрчим хүчний бие даасан байдал гэдгийг ямар хэмжээтэй үзэж байгаа бөгөөд энэ эрчим хүч 3 төсөл нь өөрөө тэрний хэд орчим хувийг эзэлж байгаа юм бэ?

Цаашлаад ер нь эрчим хүч-3 гэдэг шиг 4, 5 гээд ер нь ингээд дараагийн цуврал төслүүд ямар хэмжээнд байгаа юм. Нийтдээ ер нь бид нар ямар хэмжээтэй энэ төслүүд хэрэгжүүлэхэд Монгол Улс одоо эрчим хүчний бие даасан байдалд бүрэн орох боломжтой вэ гэсэн ийм асуултууд байгаа юм. Тэгэхээр асуултын хариултаас үүдээд тодруулга авъя.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд эхлээд хариулаад дараа нь Чойжилсүрэн сайд 5 номер.

Б.Жавхлан: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Одоо бид энэ зээлийг соёрхон батлуулахаар орж ирж байгаа. Өмнө нь батлуулахаар нэг сард хэлэлцээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор одоо дэмжигдсэн та бүхэнд баярлалаа. Тэгэхээр одоо бидэнд олдож байгаа хамгийн зөөлөн сайн нөхцөлтэй зээл маань л ерөөсөө энэ бид яах вэ олон улсаас энэ 2 төрлийн зээл авч байгаа. Би нөгөө бондоос гадна хэлж байна шүү. IPO-д буюу олон талт хөгжлийн институцүүдээсээ авна. Дэлхийн банк ОУВС, АХБ, Азийн хөрөнгө оруулалт дэд

бүтцийн банк Европын сэргээн босголт хөгжлийн банк гээд өнөөдөр энэ авч байгаа. Бусад нь мөн одоо яах вэ? Бид нар өмнө нь яах вэ? Донор орнууд гэдэг байсан. Одоо энэ 2 талтын ийм зээлүүд 2 төрлийн ийм зээл авч байгаа.

Хоёр талын одоо хамгийн 2 талтын зээл гэх юм бол хамгийн сүүлийн жишээ Энэтхэгээс авсан нефть боловсруулах үйлдвэр байна. Энэ хүү нь бага 1.5-аас бага гэсэн үг. Гэхдээ Энэтхэгийнхээ экспортыг дэмждэг ийм зээл. Энэтхэгээс худалдан авалт хийх ёстой. Энэтхэгийн одоо тэр өөр компаниуд 1 дүгээр ээлжид наашаагаа орж ирж одоо бэлтгэн нийлүүлэлт хийгддэг ч юм уу тэрийг нь бодохоор энэ одоо Европын сэргээн босголт банкнаас авч байгаа энэ софер 1.4-өөс бараг илүү зарим талаараа зардалтай болоод явчихдаг.

Яг олон талтаас авч байгаа зээлүүд одоо бид өнөөдрийн байгаа энэ хэмжээн дээр нь ялангуяа дэд бүтцийн ийм санхүүжилтүүдээ яаралтай олдож л байвал авч байх хэрэгтэй. Дэд бүтцийнх дээр шүү. Нийгмийн чиглэлийн биш дэд бүтцийнх дээр хатуу дэд бүтцийнх гэсэн үг.

Өөрөөр хэлбэл хатуу дэд бүтэц маань одоо хувийн хэвшил хөрөнгө оруулалт ордоггүй. Гаднын хөрөнгө оруулалт одоо шууд хөрөнгө оруулалт ашгийн төлөө ч юм уу хөрөнгө оруулалт хэзээ ч хийгдэхгүй. Маш их урт хугацаанд одоо ашиг, үр өгөөжөө өгдөг. Харин дэд бүтэц гэдэг утгаараа бол ашиглалтад орлоо. Тэрнээс хойш одоо яг нийгэм, эдийн засгийн яг суурь өртгийг хямдруулж өгдгөөрөө бидэнд хамгийн чухал ийм салбар байдаг.

Тийм учраас одоо яг дэд бүтэц дээр бид нарын олдож байгаа гарцаагүй одоо хамгийн сайн нөхцөлтэй зээл нь л одоо яг энэ байгаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд 4 номер.

Б.Чойжилсүрэн: Эрдэнэболд гишүүн ээ энэ төслийг яагаад хэрэгжүүлж байгаа юм гэж.

Нэгдүгээрт яг өнөөдрийн байдлаар байгаа байдал юу вэ гэхлээр Оюу Толгой төсөл жишээлбэл жилдээ 140 орчим сая доллар энэ жилийн гүйцэтгэлээр магадгүй 150 сая доллар гарах байх. Иймд цахилгаан эрчим хүчийг БНХАУ импортолж авч байгаа. Оюу Толгой төслийг Монгол талаасаа одоо цахилгаан эрчим хүчээр хангана гэдэг ийм хөрөнгө оруулалтын гэрээний заалт бий. Энэний дагуу одоо ямар ч байсан эхний ээлжид өнгөрсөн жилүүдэд 1.3 тэрбум квт цахилгаан эрчим хүчийг дотоодын эрчим хүчний системээс нийлүүлнэ гэж байгаа юм. Оюу Толгой төсөл маань өөрөө мэдэж байгаа олон улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй.

Нэгдүгээр зэргийн хэрэглэгч ээ. Зөвхөн нэг цахилгаан станцаас нэг эх үүсвэрээс бол энийг хангах юм бол Оюу Толгой төслийн одоо тэр баяжуулах үйлдвэрийг хэрвээ зогслоо гэж байгаа тохиолдолд цахилгаан эрчим хүчний саатал гараад учрах хохирол аягүй өндөр.

Тийм учраас заавал 2 талаасаа 2 эх үүсвэрээс одоо хангах ёстой. Энэ бол Багануур, Чойр. Тэгээд Чойр-Сайншанд, Сайншанд-Цагаан суварга гээд энэ 220 квт –ын 1 дүгээр ээлж ашиглалтад орчих юм бол нэг талаасаа бид нар энэ Багануур орчим Төв аймгийн Баян, Баянжаргалан сумууд дээр баригдаж байгаа

Бөөрөлжүүтийн станц энэ Баянгийн станц болон бусад станцуудаас нэг талын эх үүсвэр үүснэ.

Дараагийнх нь Тавантолгойн цахилгаан станцыг барьсан тохиолдолд 2 дахь эх үүсвэр үүснэ. Эс бөгөөс бид нар одоо дараагийн хувилбар болгоод энэ Төв аймгийн Баян-Өнжүүл суман дээр нэг хөрөнгө оруулагч орж ирж байгаа. 600мвт-ын хүртэлх хэмжээний цахилгаан эрчим хүчийг юунд нийлүүлэе ээ гэдэг ийм одоо төсөл хэлэлцээр хийгээд явж байна. Энийг бид нар одоо Дундговийн төв Мандал дэд станцтай холбожих юм бол 2 талаасаа цахилгаан эрчим хүчээр хангана. Одоо ямар нэгэн эрчим хүчний сааталтгүй 1 дүгээр зэрэглэлийн хэрэглэгчийн тавигдаж байгаа шаардлагад нийцүүлэх хэмжээний ийм эрчим хүчээр хангах бололцоо бүрдэх юм.

Ер нь зүгээр олон талын арга хэмжээнүүд бий. Хамгийн том нь энэ. Ингэсэн тохиолдолд энэ Хятад улсаас импортолж байгаа энийг тодорхой хэмжээнд бид нар бууруулна аа. Шаардлагатай бол техникийн хувьд бэлэн болсны дараа энэ асуудлыг ярихгүй бол бэлэн болоогүй байж бид нар энэ талаар яриад байх юм бол нөгөө талаасаа эд нар чинь улсууд өөрөө өөрийгөө л бодно шүү дээ энэ чинь. Ийм байдалтай явж байгаа. Тэр Үндэсний байдалгүй байдлын зөвлөлийн таны яриад байгаа зүйл 2020 онд одоо эрчим хүчний хувьд тусгаар тогтнол гэсэн ийм зорилт туссан. Харамсалтай нь өнгөрсөн жилүүдэд янз янзын л зүйл боллоо. Ковид гэх мэт.

Өнөөдрийн байдлаар бид нар яг эрчим хүчний бүрэн хараат бус байдлаа хангаж чадаагүй байгаа нь үнэн. Дараагийн эрчим хүчний бусад улс төрийн бичиг баримтууд, төрийн бичиг баримтууд дээр бол энэ зорилт бол мэдээж үе үеийнхний үед л бол эрчим хүчний үгүй ядаж эрчим хүчнээсээ гаднаас хараат бус байа гэдэг энэ зорилго мэдээж тусгаар улсын хувьд бол тэргүүн ээлжийн зорилт байна. Энд бичиг баримтууд дээр бол тухай бүрд нь энэ зорилтууд суугаад явах байх гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Тэр хатуу дэд бүтцийн төслүүд дээр ер нь энэ зээл авах гэдэг Сангийн сайдын байр суурийг бол дэмжиж байгаа. Тэгэхээр бид нар энэ гадаад харилцаан дээр хариуцлагатай хамтрагч байх тал дээр, дээрээс нь тэр улсын зэрэглэл дээшилсэн тохиолдолд бид ч гэсэн энэ эрх зүйн субьектийн хувьд бас цаг хугацаандаа гэрээгээ байгуулдаг, цаг хугацаанд нь өр төлбөрөө төлөөд явдаг эд нар гэсэн энэ зүйлийг дэмжиж байгаа.

Чойжилсүрэн сайдаас зүгээр түрүүн би асуултаа ойлгуулаагүй юм шиг байна. Саяын хариултыг ойлгочихлоо. Одоо бид нар нөгөө ингээд тусгаар одоо эрчим хүчний бие даасан байдал гээд байгаа юм шүү дээ. Энэ зорилт байгаа шүү дээ. Тэгээд 2020 он гэхэд одоо биелээгүйгээр 5 жил өнгөрөөд явж байгаа ойлгож байгаа. Ямар нэгэн ковидын нөхцөл байдал улс төр, эдийн засаг гээд ингээд бүгдийг нь ойлгож байгаа. Тэгэхдээ ер нь бид нар яг энэ боломжтой түвшинд эрчим хүчний бие даасан байдлаа хангана гэдэг бол яг ямар хэмжээний тийм одоо тэр багтаамжийг ойлгох юм бэ гэдгийг хэлээд байгаа.

Мэдээж энэ нийгэм хүн ам өсөөд одоо юу гэдэг юм үйлдвэрлэл өсөхийн хэрээр энэ эрэлт нэмэгдэнэ тэрийг ойлгож байгаа. Гэтэл одоогийн бидний байгаа нөөц нөхцөл байдал яг ойролцоогоор нэг хувилах нь хаашаа юм гэхдээ яг ямар

түвшинд байгаа юм бэ? Тэгээд эрчим хүч 3 гэж байгаа шиг магадгүй 4, 5 гэсэн хэчнээн ийм төсөл ямар хэмжээтэй төслийг хийхэд бид нар одоо нөгөө алсын зургаа ойлгох гээд байна шүү дээ. Одоо ер нь бол Их Хурал ч тэр шийдвэр гаргалтын түвшинд ямар түвшинд бид нар энэ дээр хийхэд магадгүй цаанаа нарийвчлах юм бол ямар одоо санхүүгийн сурвалжтай хийхэд бид нарт ер нь одоо бид нар ер нь харьцангуй энэ үндэсний аюулгүй байдлын түвшнийг хангахуйц эрчим хүчний бие даасан байдлаа хангаж байна гэж үзэх юм бэ л гэсэн асуулт асуугаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя. 4 номер.

Б.Чойжилсүрэн: Эрдэнэболд гишүүн ээ ингэнэ. Тийм абсолют бие даасан байдалд манайх шиг жижиг орон очиж чадахгүй юм шиг байна лээ. Бодит байдлыг хүлээлтэд зөв ярьсан нь дээр. Одоо манайд 1984 онд хамгийн сүүлд ТЭЦ-4 баригдсанаас хойш ДЦС баригдаагүй явж байна шүү дээ. Өнгөрсөн жил хамгийн эхнийх нь бол хувийн салбарынхан Бөөрөлжүүт дээр 150мвт-ын зүгээр цахилгаан станц орд дээрээ барьсан. Ийм байдалтай байгаа. Манайх жишээлбэл цахилгаан эрчим хүчний энэ тоноглолыг үйлдвэрлээд дотооддоо экспортлоход бид нар үнэхээрийн бусад улс орнуудтай дийлэхгүй өрсөлдөж дийлэхгүй.

Тийм учраас тоноглолыг бол бид нар импортоор авч л таарна. Тэгэхээр миний хувьд бол бие даасан байдал гэж улам их хошуурахаасаа түрүүлээд одоохондоо санхүүгийн нөхцөл байдлаа харж байгаа учраас үр ашигтай байдлаа 1 дүгээрт тавивал яасан юм бэ?

Магадгүй санхүүгийн бололцоотой болоод одоо энэнээс хойш цаашаа магадгүй 10, 20 жилийн дараа бие даасан байдлаа хангах тухай ярихаас биш энэ бүх юмыг гэв гэнэт ингэж туйлшраад ийм байж чадахгүй болов уу гэж бодож байна. Энэ тоног төхөөрөмжүүдийг бид нар ийм цахилгаан станцын тоног төхөөрөмжүүдийг манайх үйлдвэрлээд дийлэхгүй. Манай дотоод хэрэглээ байхгүй. Тэгэхээр энэ чинь энэ том улсын зовлон, жижиг улсын зовлон гэж байгаа учраас энэ бие даасан байдлаа ямар шалгуураар яаж дүгнэх юм гэдгээ бид нар эргэж харсан нь дээр болов уу гэж. Одоохондоо миний хувийн байр суурь бол үр ашигтай байдлаа манай энэ зээлжих орон зай энэ дөнгөж хөгжиж ирж байгаа ганцхан эрчим хүчний салбар биш бусад салбарууд дээр зээлжих орон зайгаа бүгдийг нь эрчим хүчний салбар дээр туйлшраад аваад хэрэглэхгүйгээр баланстайгаар тулгамдсан энэ улс ардын аж ахуйн салбарууд дээр бүгдтэй нь ингээд ийм баланслагдсан бодлого яваасай гэсэн байр суурьтай байгаа.

Гэхдээ алхам алхмаар гадаад хамаарлаа бол багасгаад яваад байх ёстой. Энэтэй бүүр санал нэг байна. Бүрэн бусдаас хамаарахгүй гэдэг ийм том зорилго бол жижиг орны хувьд хэцүү.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Эрчим хүчний асуудал чухал. Энэ дэд бүтцийн асуудлыг мэдээж хэрэг улс орон өөрөө өөрсдөө шийдэх ёстой тэрийг ойлгож байна аа. Гэхдээ энэ одоо зээл авдаг цаг биш ээ. Ер нь гадна дотноос зээл авах нөхцөл байдал их сайнгүй байгаа шүү дээ. Одоо хамгийн багадаа л 4, 5 хувийн хүүтэй ийм зээл авч таарах нь. Хэдийн хөнгөлөлттэй ч гэсэн. Энэ 47 сая доллароо та бүхэн өөрсдөө шийдчихвэл яадаг юм бэ. Яагаад вэ гэхээр одоо их сайхан болчихлоо. Их мундаг ажиллаад байгаа энэ тэр гээд л яриад байгаа шүү дээ. Тэгээд гэрэл цахилгааны

үнийг нэмсэн, дулааны үнийг нэмсэн. Ийм одоо нэмчихсэний дараа ингээд бид бүхэн бол үнэхээр сайн ажиллаж чадна гээд ингээд ярьсан шиг санагдаад байх юм. Бараг л тэрийгээ реформ гэж хэлээд байсан. Гэтэл одоо яамаар байна аа амьдрал дээр. Одоо их олон толгойтой болчихсон та нар чинь, тэр яриад байгаа нь бол. Тэр Шадар сайд хэн билээ. Тэр нөхрийн чинь гадна дотно яваад яриад байгаа юм нь бол одоо бүр эрчим хүчний илүүдэлтэй орон болчихсон. Өнөө маргаашгүй бид нар экспортлох гэж байгаа л гэж яриад байсан шүү дээ.

Тэгсэн чинь одоо доторх одоо хэдэн цахилгаан шугам сүлжээгээ хийх ийм мөнгөгүй болчихлоо гэсэн юм яриад байх юм. Энэний өмнө одоо миний мэдэж байгаагаар 4 дүгээр цахилгаан станцын тоног төхөөрөмжийг солино гээд нэлээн их долларын зээл авна гэсэн юм ярьж байсан. Аюулгүй байдлын байнгын хороогоор ороод гарсан. 800 сая доллар билүү ингээд авсан. Зээл авчихсан уу аваад хэрэглэж байгаа юу юу болсон тэр эсвэл нөөцдөө явж байгаа юу. Ингээд ийм юмнуудаа тодруулаач ээ. Нөгөө талаар яах вэ эрчим хүчний сайдын маань та чинь 5 жил ажиллачхав уу энэ сайдаараа. Яах вэ яг байгаа байдлыг хэлээд байгаа юм шиг байгаа юм. Болохгүй юмаа болохгүй гэдгийг нь. Нөгөө том толгойнууд нь эрчим хүчний хороо ч гэж байх шиг байна. Одоо Шадар сайд нь хариуцаж байна ч гэх шиг. Одоо энэ хүмүүс чинь нийлээд одоо юу хийгээд яагаад байгаа юм бэ? Энэ юм чинь одоо амьдралаар яагаад биелэхгүй байна вэ? Нөгөө талаар энэ дулааны станц байна аа. Баянхонгор, Архангай уул нь 10 л даа. 10 аймагт байгаа. Баянхонгор, Архангай, Өвөрхангай.

Тэр одоо утаандаа дарагдаад ингээд дуусчихсан. Бас зээл аваад хийж байгаа.

Гэтэл энэ юм маань одоо зогсож байна гэх юм. Энэ юмаа одоо яах юм бэ? Өвөл одоо утаагаа дийлэхгүй болчихдог шүү дээ. Энэ аймгууд бол. Тэрийг хийхдээ бас дулаан цахилгааны эрчим хүчний станцыг давхар хийчхэж болоогүй юм уу? Бид нар одоо нүүрсний цахилгаан станцуудаа хурдан түргэн оруулаад ингэж ажиллах ийм одоо таатай үе үүссэн байсан шүү дээ. Уул нь бол эрчим хүчний илүүдэлтэй эрчим хүчийг гаргаад өөрийгөө хангаад явах ийм боломжтой улс орон. Тэр Багануурын 800мвт-ын цахилгаан станцыг бол тухайн үед нь 7, 8 жил арваад жилийн өмнө зогсоосон хүн нь бол та. Энэ манай эрчим хүчний сайд биш юм шиг байгаа юм. Даваасүрэн сайд би биш гэсэн. Ийм ажлуудаа ингээд дэс дараатай сайн хиймээр байна аа бодлоготой. Энэ дээрээ бүхэн алдаад байна уу? Хувийн хэвшлийг оруулаад тэр шугам сүлжээтэй ингээд хийгээд өгч болохгүй байна уу? Тэр Бөөрөлжүүт амжилттай орсон гэж ойлгож байна. Өшөө хүлээгдэж байгаа юу байна аа? Оюу Толгой бол тэр үнэ өртгөө хангалттай төлж байна шүү дээ. Тэрийг яагаад Монгол компаниуд хангаад байж болдоггүй юм бэ? Энэ юмнуудаа хэзээ хийх юм бэ? Гаднаас хамааралгүй болчих бүрэн боломжтой шүү дээ. Миний ойлгож байгаагаар бол хэзээ ийм болох юм бэ.

Нэг ярианы л хэмжээнд яваад.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя. 4 номер.

Б.Чойжилсүрэн: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Шүүмжлэлтэй хандаж байна аа. Шүүмжлэлийг хүлээж авах ёстой. Тэр 10 аймгийн дулааны станц гээд Кореа Эксим банкны санхүүжилтээр 9 аймгийн төвд

хэрэгжиж байгаа нэг дулааны станц. Сая Сангийн сайд хэлсэн. Нөгөө экспортын зээл учраас Солонгосын компаниудын дунд тендер зарлаад 2021 онд тендер зарласан юм байна. Бугсан инженер гэж компани шалгараад 2026 оны 5 сарын 31-ний дотор ашиглалтад өгнө гэж явж байснаа сая дампуурчихсан. Солонгосын дампуурлын тухай хуулиар эрх хүлээн авагч томилогддог юм байна. Шүүхийн шийдвэр гараад энэ эрх хүлээн авагч томилогдсоны дараа энэ компанийн хэрэгжүүлж байсан төслүүдийн алийг нь зогсоох юм, алийг нь цааш нь үргэлжлүүлэх вэ гэдэг шийдвэр гарах юм байна эрх хүлээн авагчид.

Тэгэхээр энэ юу 6 дугаар сардаа багтаад энэ шүүхийн шийдвэр нэг талдаа гарсны дараа энэ төслийн цаашаа хувь заяаг цаашаа ярина аа. Ийм одоо харамсалтай үйл явдал болсон гэдгийг та бүхэнд хэлье ээ. Энэ 4 дүгээр цахилгаан станц дээр бол тийм 8 зуугаад сая долларын зээлийн тухай яриагүй ээ Ганбат гишүүн ээ.

3 дугаар цахилгаан станцын өргөтгөлийн талаар ОХУ-ын Засгийн газрын экспортын зээлээр хэрэгжүүлэх тухай хэлэлцээр хийгдээд явж байгаа. Өнгөрсөн жил бас танай Байнгын хороогоор оруулаад энэ асуудлыг нь зураг төсвийн тухайд нь бол одоо Улсын Их Хурлын гишүүд та бүхэн дэмжиж зураг төсвөө хийчих ээ. Түүний дараа үнэ тохирно гээд байгаа Оросын талын байр суурийг бид нар дэмжээд ийм ажил явж байна. Зураг төсвийн гэрээнүүд нь хийгдээд ойрын нэг 2025, 2026-оны төгсгөл гэхэд зурагтай төсөвтэй болох байх. Тэрний дараа яг одоо бодит үнэ тогтнож энэ зээлийг авч ашиглах уу, ашиглахгүй юу, Оросын экспортын Засгийн газрын экспортын зээлийг авах уу үгүй юу гэдэг энэ сэдвийг бол ирэх жилдээ бүхэнд оруулж ирж танилцуулна гэдгийг хэлье ээ. Энэ Ганбат гишүүн ээ. Нэг зовлонтой юм байгаа нь бүх улс орнууд дээр энэ цахилгаан дамжуулах энэ хуваарилах байгууламж агаарын шугамуудыг дандаа төрд байдаг. Хувийн салбарыг энэ рүү оруулчих юм бол хувийн салбарынх нь одоо хариуцлагатай, хариуцлагагүй, санаатай, санамсаргүй үйлдлүүдээр эрсдэл үүсгэх учраас энэ төр өөрөө л авч хийхээс өөр аргагүй. Хувийн салбарын хөрөнгө оруулалтыг одоо энэ рүү хөрөнгө оруулаад дараа нь энэ ашгаа олоод эндээс авна аа хувийн салбарынхан хөрөнгө оруулна аа гэдэг бол ямар ч одоогийн байгаа нөхцөл байдалд боломжгүй зүйл учраас одоо засаг өөр дээрээ л дээ шүүмжлэлтэй ч зээл авч байгаа нь нэг сайн зүйл биш. Гэхдээ эдийн засгаа тэлэхийн тулд эрчим хүчний салбарын боомиос гарахын тулд гарцаагүй л энэ дэд бүтцийн зээлүүдийг авахаас ондоо аргагүй ийм байдалд үүсэж орчхоод байгаа юм.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд 5 номер.

Б.Жавхлан: Ганбат гишүүний тэр зээлтэй холбоотой асуулт дээр би нэмж хариулъя аа. Ганбат гишүүн ээ хэрвээ болдог бол зээл авмааргүй л байгаа юм. Гэвч бид өнөөдөр хөгжиж буй орон, хөгжиж буй орны хувьд дэд бүтэц гэдэг бол хамгаас чухал. Цаашдын эдийн засгийн өсөлт нийгмийн эдийн засгийн энэ хүртээмжтэй эдийн засгийн өсөлт гэдэг хамгийн том гол суурь өртөг нь бол энэ дэд бүтцүүд байдаг. Ялангуяа зам тээвэр, эрчим хүч, дулаан гээд. Энийг одоо төр өөрөө эзэмшихээс өөр арга байхгүй. Сая Чойжилсүрэн сайд маань хэллээ.

Дээрээс нь одоо жишээ нь энэ 188 км юм байгаа. Дээрээс нь чиглэлийн яамнаас өгч байгаа мэдээллээр одоо нэгэнт суурилагдсан байгаа манай эрчим хүч дулааны одоо хэрэглэгчдэд нь хүргэж өгөх энэ түгээлтийн шаардлагатай цахилгаан дамжуулах агаарын шугамын хэрэгцээ 1842 км. Тэгэхээр энэ дөнгөж аравхан хувь

нь юм байгаа юм. 10 хувь дээрээ бид 47 сая долларын хөрөнгө оруулалт хийж байна. Тэгэхээр одоо 10 дахин илүү гэхээр бараг хагас тэрбум долларын ийм хэрэгцээ байгаа гэсэн үг.

Тэгэхээр энийг бид өнөөдөр төсвөөрөө нэг мөр нэг амьсгаагаар дийлэхгүй байгаа юм. Тийм учраас энийгээ зөөллөөд нэг 30 жилийн хугацаанд ачааллуудыг нь нэг багасгаад ингэж хойш нь шидээд ингэж авна гэдэг бол энэ бол бидэнд өнөөдөр одоо ус агаар мэт байгаа ийм хөрөнгө оруулалт санхүүжилттэй гэж бид харж байгаа.

Ийм ч одоо дунд хугацааны хөтөлбөрүүдээ зарчмуудаа Их Хурлаар батлуулаад ингээд явж байгаа. Таны хувьд бас хувийн секторын зовлон жаргалыг хамгийн сайн ойлгох гишүүдийн нэг. Тэгэхээр энийг одоо ойлгож дэмжинэ ээ гэдэгт одоо найдаж байна. Тэгэхээр төр энийг хийж, төр энийг өөрөө эзэмшиж, цаашид одоо арчилгаа үйлчилгээг нь авч явахгүй л бол ийм нийтийн хэрэгцээний ийм дэд бүтцийн шугамыг хувийн хэвшил гаднын хөрөнгө оруулалтынхан одоо хэзээ ч хийхгүй л дээ. Тийм учраас одоо энийг байгаа одоо боломжуудаасаа одоо хамгийн болох нь л одоо энэ гэж үзэж ингэж орж ирж байгаа асуудал юм байгаа юм шүү. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Тэгээд одоо эрчим хүч юу билээ жил болгон одоо хэдий хэмжээний дутагдаад явах вэ цаашдаа. Одоо эдийн засаг өсөж байгаа гээд байгаа шүү дээ. Тэр дутагдлаа одоо яаж нөхөх вэ гэсэн ийм асуулт байна. Та бүхэн ярихдаа бол энэ Засгийн газар шүү дээ мега төсөл болж байна их олон юм хийнэ барина гээд байх юм. Тэгээд эрчим хүчний байдал чинь ийм байж байж юу ийм худлаа ярихаа одоо больчихмоор юм аа. Ямар юмны одоо мега төсөл байх вэ дээ. Ийм юмаа шийдэж чадахгүй байж байж. Тэгээд уул уурхайн компани гадагшаа гардаг экспорт хийдэг компани бүгд нарын мэдэлд байгаа шүү дээ. Тэр Оюу Толгойн 34 хувь, Эрдэнэс Тавантолгой энэ тэр гээд. Үгүй ээ тэрийг чинь гаргаад тэрний чинь ашиг машиг нь одоо хаачдаг юм тэрүүгээрээ хийчхэж болдоггүй юм уу?

Түрүүчийн хийсэн одоо энэ дулааны станц гэхэд тэрний хариуцлагыг хэн хүлээх юм бэ? Энд одоо хариуцлага хүлээдэг Монгол талаасаа хүн байна уу байхгүй юу? Тэгээд л тэгчихсэн тэгээд дууссан. Ард нь тэгээд Баянхонгорын, Өвөрхангайн, Архангайн ард түмэн хохироод л үлддэг. Нөгөө 10 аймгийн ард түмэн хохирдог. Хойшлоод л тэд нар авах байсан тэр үйлчилгээгээ авч чаддаггүй. Утаандаа хордоод л, ингээд үлддэг ийм байж болохгүй биз дээ. Хүү нь болохоор явдаг юм уу, явдаггүй юм уу? Тэгээд одоо нөгөө компанитайгаа хэрүүл хийж байна гэсээр байгаад тэр шүүхийн ажиллагаа нь хэдэн жил ч үргэлжлэх юм. Энэ их юмыг одоо даруй хурдан хугацаанд шийдэж болох уу?

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд 4 номер. Асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Эрчим хүчний дутагдлаа яаж нөхөх вэ гээд ингэж байна. Жилд одоо яг оргил өвлийн оргил ачааллын үед бол 2023, 2024 онууд дээр бол 12 хувийн өсөлтүүдийг хийгээд яваад байгаа юм. Өнгөрсөн жилийн төгсгөлөөр бид нар одоо 2024 оны 12 сард манай төвийн бүсийн эрчим хүчний систем дээр хамгийн өндөр ачаалал 1800мвт хүрсэн. Ийм байдалтай. Энийг хангахын тулд хэд хэдэн арга хэмжээ аваад

явж байгаа. Яг өчигдөр яриад өнөөдөр бид нар биелүүлж чадахгүй. Манай энэ салбар бол зөв ойлгоорой. Төсөл хэрэгжүүлээд барилга угсралтын ажил эхэлснээс хойш 30-аас 36 сард шаардлагатай болчихоод байна. Ямар ч байсан эхнийхээс нь энэ дутагдлаас яаж гарах вэ гэхлээр Бөөрөлжүүтийн цахилгаан станцын эхний 150мвт-ыг төвийн сүлжээнд холбосон. Энэ 12 дугаар сард энэ оны 12 дугаар сараас 2 дугаар блокийн 150мвт-ын блокийг холбоно. 2028, 2029 онууд дээр 3, 4 дүгээр блокуудыг холбож байгаа. Түүнээс гадна Төв аймгийн Баян суман дээр 660мвт-ын цахилгаан станц барилга угсралтын ажил явж байна. 2027 оны 6 сарын 30 гэхэд эхний блокийг ашиглалтад оруулахаар явж байгаа ийм асуудал байна.

Түүнээс гадна Сэлэнгэ аймгийн төв дээр Сүхбаатар хотод 70мвт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажил явж байна. Тосонцэнгэл сум дээр 30мвт-ын цахилгаан станцын эхний 22мвт-ын хүчин чадлыг бид нар сүлжээнд холболоо. Түүнээс гадна Говьсүмбэр аймгийн Шивээговь сум дээр Шивээгийн уурхайн хажууд дахиад нэг 660мвт-ын нүүрсний цахилгаан станц одоо ингээд энэ ондоо багтаагаад чадвал 8, 9 дүгээр сардаа юу хөрөнгө оруулагчид нь олдчихсон ашиглалтад орно. Тэгэхээр 36 сарын дараа бид нар ашиглалтад авах болов уу гэсэн ийм тооцоолол байна. Гэх мэтээр бид нар ямар ч байсан нэг 27 оны 6 сарын 30 гэхэд ямар ч байсан энэ хэрэглээгээ нэг удаа гүйцэж авна аа. Түүнээс цаашаа бол ямар ч байсан энэ цахилгаан эрчим хүчний чадлын дутагдалд орохгүй байх ийм л бололцоо бүрдэж байгаа. Иймэрхүү байдалтай байгаа. Хүнд байгаа хэдий боловчиг хэцүү байгаа хэдий боловчиг зовлон дуудаад суугаад баймааргүй байна.

Дандаа энэ ард түмэн чинь ийм шалтгаан хэлмээргүй байна. Ажлаа хий, үр дүн гарга гэдэг ийм шахалтад байгаа учраас бид нар бас л цаг наргүй ажиллаж байгаа гэдгийг танд хэллээ. Энэ 10 аймгийн ДЦС-ын тухайд бол ийм харамсалтай үйл явдал болсон. Миний урд талын сайд одоо манай яамны ТНБД-аар ажиллаж байгаа. Чи яагаад ийм одоо эрсдэлтэй ААН шалгаруулчихдаг юм бэ чи төрийн нарийны хувьд энийгээ дуусга гэдэг ийм шаардлага тавьсан. Харамсалтай нь ингээд сүүлийн би одоо яг 2022 оны 8 сараас хойш эрчим хүчний сайдаар ажиллаж байна. Явсаар байгаад л ухнатсаар байгаад л нэг ийм төвөгтэй байдалд орчихсон. Одоо энэ шүүмжлэл шаардлагыг хүлээж авч байна аа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Санал хураалтыг явуулж эхэлье.

Эрчим хүч 3 төслийг хэрэгжүүлэх Монгол Улс олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг бол явуулна. Гишүүд хангалттай байна.

Санал хураалтын бэлэн байдалд шилжье. Бүгд төхөөрөмжүүдээс гарсан байгаа. Хуруугаа дахиж уншуулаад санал хураалтын бэлэн байдалд шилжье. Гишүүд хуруугаа уншуулаарай. Цогтоо гишүүн бүгд уншуулчихсан байгаа байх тиймээ?

Санал хураалтын горимд шилжсэн байна. Бэлэн байдалд байгаа 9 гишүүн байна. Ирж байгаа гишүүн байгаа юу? Санал хураалтыг явуулна гишүүд анхааралтай байгаарай.

Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Шууд дарахаар байгаа. Дарна хуруугаа уншуулахгүй.

66.7 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа Засгийн газрын гишүүдэд баярлалаа. Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганд илтгэх байгаа.

Саналаараа илтгэх гишүүн байна уу? Энэ 4 дэхэд байгаа юу? 4 дэх өдөр байгаа байх.

Алтаншагай гишүүн илтгэе. Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан байна аа. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

11.00 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА